

**МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН УРАН ЗОХИОЛ ДАХЬ ЗОРИУЛАЛ ШҮЛЭГТ
Д.НАЦАГДОРЖИЙН ДҮРИЙГ БҮТЭЭСЭН НЬ**

(Гунигийн буюу харууслын уянгын зориулал шүлгийн жишээн дээр)

Т.Нямхүү¹

Монголын орчин үеийн уран зохиолд суут зохиолч Д.Нацагдоржийн гунигийн буюу харууслын уянгын зориулал шүлгээр эхлэлээ тавьсан арван нэг, хоёр цуврал шүлгүүд бол энэ хэлбэрийн шүлгийн анхдагч нь байв.

Утга зохиол судлагч доктор Д.Галбаатар энэхүү зориулал шүлгийн талаар “Зориулал шүлэг нь өөрөө өөртөө зориулж өөрийгөө байцаан, ажил үйлсээ шинжиж тодорхойлсон хэлбэрээр тохиолдоно” хэмээн “Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны товч тайлбар толь” Токио., 2002 х 101 номдоо зөвхөн зориулал шүлгийн тухайд төдийгүй гунигийн зориулал шүлгийн нэр томъёоны асуудлыг нэгэн адил хөндсөн байна.

Суут зохиолч Д.Нацагдорж бидний өгүүлж буй гунигийн болон харууслын зориулал шүлэгийг уран бүтээлээрээ харуулсан төдийгүй өөрөө өөртөө болон хань ижил, үр хүүхэд, анд найз дотны нөхөртөө зориулан бичсэн нэлээд хэдэн гунигийн буюу харууслын уянгын зориулал шүлгийг бүтээн туурвисан нь зохиол бүтээлээс нь тодорхой ажиглагддаг.

Суут зохиолч Нацагдорж өөрөө шүлэг зохиолынхоо эзэн болж явжээ. Тэрээр хорин зургаахан настай байхдаа “нийгэм журмын оюутан би” гэж өөрийгөө өөрөө алдаршуулан нэрлэж байсан удаатай. Тэр үед Д.Нацагдорж зүүний нугалаатны балмад явдал, хар муу санаатны гүтэлэг хуйвалдааны гайгаар хүнд байдалд орж байсан юм. Гэсэн ч түүнд гуьнж гутарсангүй, ардын нам, ардын засгийн ялалтад бат итгэж, цээжиндээ багтахаа больсон яруу найргаасаа чихрийн цаасан дээр буулгаж үлдээсэний нь бид бид бүхэн сайн мэдэх билээ. Түүний нь гунигийн буюу харууслын уянгын зориулал шүлгийг зохиогч яруу найрагчийн зүрх сэтгэлийн өчил үг гэж хэлж болно.

Тэрхүү цуврал шүлгийн уран сайхны баатар нь уягын “би”-Нацагдорж байсан юм. Аль ч үеийн яруу найрагчид уянгын “би”-г яруу найргийнхаа уран сайхны баатар болгон дүрсэлж ирсэн түүхтэй. Уянгын “би” бол тухайн нийгмийн тодорхой үзэл санааг илэрхийлж байдаг учиртай. Түүний гол учир утга уянгын “би” бол сэтгэлийн хөдөлгөөнийг нээн харуулдаг онцлогтойгоороо бусдаас өвөрмөц онцгой дүр юм. Эртний үеийн монголын яруу найрагт түүнийг “хэлсэн үг” гэж томъёолж байжээ. Уянгын “би” бол яруу найргийн зөвхөн хэрэглээний зүйл биш, харин тэр нь тухайн үеийн ертөнцийг үзэх үзэл, нийгмийн амин гол асуудал, гол зөрчлийг тусган харуулсан уран сайхны дүр юм. Уянгын “би” бол баяр баясгалан ба уйтгар гуниг, жаргал цэнгэл

¹ Ховд их сургууль

ба гаслан зовлон, итгэл найдвар ба гутрал цөхрөлийн аль алийг өөртөө шингээсэн байгаагаараа бусдаасаа ялгаатай. Д.Нацагдоржийн чихрийн цаасан дээр бичиж үлдээсэн уянгын “би”-Нацагдорж бол шинэ үеийн сэхээтний ертөнцийг үзэх шинэ үзэл, хувьсгал, ард түмэн, тухайн нийгэмдээ итгэх итгэлээр дүүрэн яваа бодит хүний дүр зураг билээ. Түүний эх дүр нь Нацагдорж өөрөө юм. Тэрээр “Эрх чөлөөг хүсэхүй” (1932) хэмээх шүлэгт шорон гянданд хоригдож байгаагаа,

*“Музей дор хоригдсон араатан шиг
Мөрнөөс хагацсан загас шиг” гэж нэрлээд,
“Мөхлөг дор учирсан миний бие*

*Мөнхийн чөлөөг мөрөөднө” [Нацагдорж.Д. “Бүрэн зохиол-1”. УБ.,
2006.109]*

гэж амьдралынхаа хүнд байдлыг тодорхойлон хэлээд байгаа хүмүүн бол “Залуу бие ганихархуй” (1932) хэмээх шүлэгтээ:

*“Өсөх бага наснаас
Өөрийн улсдаа зүтгэв”*

*“Арван хэдэн наснаас
Ардын хувьсглыг дагав”*

“Үгээгүү ядуугаар бойжив

*Үнэнч шударгаар хүмүүжив” [Нацагдорж.Д. “Бүрэн зохиол-1”. УБ.,
2006.107-108]*

гэж үнэн байдлаа илэрхийлээд байгаа хүн бол зохиолч өөрөө юм..

Ингэж яруу найрагч уянгын баатар “би”-Нацагдорж өөрийнхөө ажил амьдрал, үзэл санааны мөн чанарыг тодорхойлжээ. Тэгээд бас ардын засгийг “Өнчин надад эх”, “Ганц надад хань” болсон юм гээд нам улсын буянаар эрдмийн шимийг хүртсэн “би” бол, “Нэг ч өдөр ил явбал нийтийн боловсролд нэмэр сэн”, “Эрдэм боловсролоо энэ улсдаа зориулах сан” гэж хэлж байна. Энэ бол ардын хувьсгалын үзэл санааг ариун уураг тархиндаа шингээж ард түмнээ гэж яваа шинэ үеийн шилдэг сэхээтний шинж төрхийг уран сайхнаар дүрслэн үзүүлсэн дүр дүрслэл төдийгүй уран сайхнаар үзүүлсний тодорхой баримт мөн.

Д.Нацагдоржийн эдгээр шүлгийн уянгын баатар “би”-Нацагдоржийн зан авир, яриа бодол, үзэл санаа, эелдэг зөөлөн, уян налархай, эрс шийдэмгий зарчимч, хүнлэг хүний мөс сайтай хүний уран дүрээр дүрслэгдсэн байна.

“Хан ертөнцийн сар” (1932) хэмээх шүлгийн баатрын “би”-Нацагдорж,

“Ялгам сайхан сар минь

Ертөнц дэлхийн дэнлүү,

Янаг амраг хүү минь

Ямагт миний дэнлүү” [Нацагдорж.Д. “Бүрэн зохиол-1”. УБ., 101]

гэж байна.

Мөн уянгын яруу найргийн “Тэргэл сарыг үзэхүй” (1932) хэмээх шүлэгт,

“Тунгалаг сайхан сар нь

Туяан дундаа онцгой

Туйлын хайртай хүү минь

*Дотно зүрхэнд минь оршино” [Нацагдорж.Д. “Бүрэн зохиол-1”. УБ.,
120] гэж бий.*

Энэ нь Нэгдүгээрт: шинэ үеийн шинэ хүний сэтгэлийн хөдөлгөөн, сайн сайхан мөрөөдөл байна. Энэ мөрөөдөл биелсээр ирснийг, Хоёрдугаарт: өөрийнхөө төлөө аз

жаргалтай амьдрал, итгэл найдвараар нэвтэрхий байгааг, *Гуравдугаарт*: алтан нар, тэргэл сар, хөх тэнгэр, янаг амраг нь хувьсгалт эх орон, ард түмэн, нам, засагтаа халуун хайртай хөдөлмөрч өөдрөг сэтгэлээс урган гарснаараа тус тусын онцлогтой байгаа юм.

Суут зохиолч Д.Нацагдорж мөнх бусыг үзүүлэхээсээ 355 хоногийн өмнө “Тэргий хүүхдээсээ хагацахуй” (1936.7.23) шүлгээ туурвисан байна. Тухайн цаг үед эхнэр нь үл мэдэгдэх шалтгаанаар нутаг буцсан нь түүнд ихээхэн нэрмээс болсон байна. Энд мөн л гуниг, харууслын уянгын зориулал шүлгийн өнгө аяс илэрхий нэвт шингэсэн нь бий. Зохиолчийн бичсэнээр,

“Эцэг эх хоёул,

Энхрий охинтой гурвуул

Эндүүрч хуумгайдаж бодвоос

Энэ гурвуулангийн зовлон”

гэсэн мөр бүхий шатад амьдралынх нь цаашдын зам мөр, чиг хандлага болсон мэт санагддаг. Эхнэр Нина Чистяковагаа нутаг буцсанаас хойш сэтгэл санааны зовлон эдэлж, амьдын хагацал үзсэн хүн бол Нацагдорж юм. Түүнээс хойшх хугацаанд Д.Нацагдорж аятай тохитой ч байж чадалгүй, архи хэмээх хэцүү идээнд арай илүүтэй орж, бие сэтгэлийн гуниг гутралаар дүүрэн явж байгаад ес орчим сарын дараа учир битүүлэгээр ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ. Энэ нь тэр үедээ зөв байсан юм гэж зарим хүмүүс үзэх авч, эх дэлхийнхээ газар шороонд хүйтэн чулуу дэрлэн мөнхөд нойрсон, эхнэр ганц охиноосоо хагацсан боловч эсэргүү дайсан гэгдэж алуулахын шалтгаанаас ийнхүү салжээ гэж үздэг ч тал бий.

Энэ бүхнээс үзэхэд Д.Нацагдоржийн шорон гянданд байхдаа бичсэн шүлгүүдийн яруу найргийн уянгын баатар “би”-Нацагдорж бол шинэ хүний дүр мөн. Мөн эдгээр шүлгүүд монголын орчин үеийн уран зохиол дахь зориулал шүлэгт Д.Нацагдоржийн дүрийг илэрхийлсэн гунигийн буюу харууслын уянгын зориулал шүлгийн шилдэг дүрслэгдэхүүн болж чадснаараа онцлогтой юм. Энэ тухай доктор Д.Галбаатар тэмдэглэхдээ: “Д.Нацагдоржийн хоригдож байхдаа бичсэн гуниглалт шүлгүүд нь төр ба нийгмийн хүчирхийлэлийн өмнө эгэл хүний хувь заяаны гэнэтийн эргэлт “бие сэтгэлийн доройтол”, “санааны гунихралт байдал” хийгээд түүний эсрэг бие хүний эрх чөлөөний мөрөөдөл, хатуужил, холыг харсан итгэл, уярал, нэвчин шингэснийг үзвэл өрнө зүгт ихэд дэлгэрсэн сентименталист сэтгэлгээний хэв маяг, арга найруулгатай ихээхэн ойр бол “Цагаан сар ба хар нулимс”, “Үзэгдээгүй юм” зэрэг өгүүллэг нь реалист арга барилыг ухуулгын шүүмжлэлт шүлэг, бичил өгүүллэгт нь шүүмжлэлт реализмын өнгө аяс, “Учиртай гурван толгой” жүжиг, “Харанхуй хад” өгүүллэгээс нь далд утга, символизмын хэлбэр тодорхой харагддаг. Үүнийг их зохиолч Д.Нацагдоржид тодорхой тогтсон арга найруулга байхгүй гэлээ гэж гэнэхэн ойлгож болохгүй” [Д.Галбаатар. Удиртгал. “Монголын уран зохиолын онол түүхийн зангилаа асуудлууд”. УБ., 2009 х 15 гэсэн үнлэлт, дүгнэлтэд хүрсэнийг бид анхааран үзэх ёстой юм.

Гуниглалт шүлэг, гунигийн уянга, гунигт шүлэг, харамслын шүлэг, элеги-гуниглалт шүлэг, элегия буюу гунигийн уянга гэх мэт нэрийн дор зориулалт шүлгийн нэгэн хэлбэр болох гунигийн буюу харууслын уянгын зориулалт шүлгийг утга зохиол судлаачид тус тус нэрийдсээр өнөөг хүрч иржээ. Тэдний үзэж байгаагаар: Утга зохиолын онолын нэр томъёоны хувьд доктор Д.Галбаатар бүтээлдээ *Зориулалт шүлэг*. (dedicatkry poem) гэдэг нэрийг орчуулан зориулалт шүлэг хэмээн нэрийгтэн тодотгоожээ. Түүнээ “Зохиолч хэн нэгэн хүнд зориулан зориуд нэр заан хайрлах, бахархах, жигших, элэглэн шоолох,

анхааруулах, сэрэмжлүүлэх, шүүмжлэх зорилготой, эсвэл өөртөө болон байгаль дэлхий, уул ус, эх орондоо хандсан сэтгэлээ илэрхийлсэн шүлгүүд багтана” [Д.Галбаатар.19 x 100] гэж толь бичигтээ тайлбарласан байна.

Доктор Д.Ёндон. *Элегия-гуниглал шүлэг*. “Уянгын зохиолын нэгэн хэлбэр. Эртний грекид МЭӨ VI зууны үед янз бүрийн сэдвээр бичсэн хоёр мөрт шүлгийн хэлбэрээр үүсчээ. Европын шинэ утга зохиолд хэлбэр нь тодорхой биш болсон агуулга нь тогтвортой, их төлөв гунигтай бодол гансрал, гүн ухааны эрэгцүүллийг илэрхийлэх болжээ” [Д.Ёндон.21 x 86] хэмээн үзсэн байхад,

Доктор С.Байгалсайхан, “Терегийн гомдлын дуу гэсэн үгнээс гаралтай. Хэмжээний хувьд дунд зэргийн ухааран сэтгэх, сэтгэлийн хөөрлийг илэрхийлсэн, агуулсан (*ихэвчлэн уй гуниг*) нэгдүгээр биеэс өгүүлсэн зохиомжтой шүлэглэл юм” [С.Байгальсайхан.1 x 63-64] гэж үзжээ.

Эрдэмтэн Ш.Гаадамба. *Гунигийн уянга*. “Аж төрөл, ахуй орчиндоо сэтгэл ханамжгүйн улмаас гарсан уйтгар гунигийн сэтгэл урмыг илтгэсэн уянгын аймгийн нэг төрлийн зохиолыг гунигийн уянга гэнэ” гээд,

Уй гашуу эмэгнэл харамслын шүлэг. (Эмгэнэлийн шүлэг) “Гунигийн шүлгийн өөр нэг зүйл нь эмэгнэлийн буюу уй гашуудлын шүлэг болно. Хүний хувийн буюу нийгмийн хайр хүндэтгэлийг хүлээсэн энхрий дотнын хүний үхэж үрэгдсэний шалтгаанаар хоцрогсдын эмэгнэл гашуудал харамслын хүчтэй сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн уянын нэг төрлийн зохиолыг уй гашуу, эмэгнэл харууслын уянга гэнэ” [Ш.Гаадамба.18 x 209-210] гэсэн дүгнэт, тодорхойлолтод хүрчээ.

Доктор С.Дулам, Ц.Хасбаатар нар *Гунигт шүлэг*. “Нийгэм, аж байдлын аль нэг үзэгдэл, үйл явдлаас болж хүнийг шаналгаж байгаа уйтгар гунигийг илэрхийлсэн шүлэг юм” [С.Дулам.20 x 240] гэж тус тус тодорхойлон томъёолсон байна.

Монголын шинэ үеийн уран зохиолд ийм уламжлалт уй гашуу, эмэгнэл харамслын болон гунигийн уянга бүхий зориулал шүлэг цөөнгүй зохиогдож байв. Түүний тодорхой жишээг Д.Нацагдоржид зориулан бичсэн зохиолчдын гунигийн буюу харууслын зориулал шүлэг буй болсныг харж болно. Жишээлбэл: Д.Нацагдоржийн охин Ананда Шрийн “Аавдаа”, П.Бадарчийн “Нацагдорж гуайг өрөвднөм, “Пагдадулам”, Болд-Эрдэнэнийн “Д.Нацагдоржийн сүүлчийн өдөр”, “Бодол”, Т.Галсангийн “Мөнхжил олсон найрагч”, О.Дашбалбарын “Нацагдорж”, “Биднээс өмнө амьдраад явагсад”, Г.Донидын “Найрагч шиг найрагчийн дурсгалд”, З.Доржийн “Миний үйлдсэн нүгэл”, Н.Нямдоржийн “Их Нацагдоржийгоо үгүйлэн өмөөрсөн шүлэг”, Д.Цоодолын “Гүний нууранд агсам тавьж байж ам руугаа алгадуулав”, З.Ядмаагийн “Харуусал” зэрэг шүлгээс мэдрэгддэг.

П.Бадарчийн “Нацагдорж гуайг өрөвднөм” (1991) шүлэгт, [П.Бадарч.2 x 18-19] Зүүд зөн совингийн улбаатай байдаг гэж хүмүүс ярьдаг. Суут зохиолч Нацагдоржийнхоо гундаж гутарч явсан мөч бүрийг эргэн санаж, нэхэн дурсаж байгаагаар бичсэн энэ гуниг, харсуулын зориулал шүлэг эцэг, охин хоёрын элбэрэл журмын холбоо хамаарлыг тусгаснаараа өвөрмөц болжээ. Тэрээр:

“Гурван настай охиноо

Ямар их санаа бол

Гудамж зээлийн газраар

Яаж гуниж явсан бол...”

“...Амраг хайртаасаа хагацаж

Мөрөөдөхийн жаргалыг бус

Ахиад учрахгүй гайхамшигт
Мөлхтлөө цөхөрсөн биз хөөрхий... ”
“...Хаяж нэгэнтээ одсон ч
Эргэж энэрэх ухаантай
Хайрын нь тэнгэр явсан
Пагмадуламдаа яасан их баярлаа бол ”

“Туравхан настай охиноо

Яасан их санаа бол

Гучин нэгхэн насандаа

Яаж гуниж яваа бол

Өрөвдөж таныгаа хайрлахуй

Өр зүрх минь эмтэрхий

Өөрөө яг л тэгж яваа юм шиг

Өглөөг хүлээх нойрондоо би хар дарсан зүүдтэй ”

хэмээн харамсал гунигаа илэрхийлэн бичсэн бөгөөд, Д.Нацагдорж бас хань ижлээсээ хагацаж, орон шоронд хилсээр ял хэргэм сонсож, гүтгэгдэн сууж, уйтар гунигийг амсаж байсан үе бий. Тэрээр “Пагмадулам” гэдэг шүлэгтээ, “Хайрлам сайхан залуу насандаа, Д.Нацагдоржтой минь учирсан, харуусаж барамгүй хайраа цуцлуулж Д.Нацагдоржоос минь хагацсан Пагмадуламын тухай харуусан өгүүлээд тэрхүү Пагмадуламыг Галуутайн хөх наранд цэцэглээгүй азгүй бор лянхуа чи, гэргий нь болж Нацагдоржийнд суугаагүй, аяа хөөрхий амрагхан Пагмадулам, алагхан зүрхэндээ ашид би чамайг хайрланам, харамснам” [П.Бадарч.3 х 141] гэж зохиолчийн гэргийн золгүй хувь заяаг гуниг, харууслын зориулал уянгын шүлгийн хэлбэрээр бичсэн ажээ.

Яруу найрагч Ж.Болд-Эрдэнэ “Д.Нацагдоржийн сүүлчийн өдөр” (1989) хэмээх шүлэгтээ:

“Арван хоёрны орой...

Ардын хувьсгалын баяр наадам

Өндөрлөсөн орой...

Буянт-Ухаагаас Улаанбаатар хүрэх замд

Буцаж явсан олны дунд

Бүрх малгайгаа гартаа атгасан их-хүн

Цэнхэр тэрмэн дээлэн дээр

Улбар шар бүс жавхайтал ороож

Цэцгэн дундуур алхаж явлаа.

“Их жанжинтайгаа дөрөө харшуулан

Ирж байсан наадмаас хойш

Арван таван жил өнгөрчээ...

Эддээ Жанжин маань байсан бол

Ингэж ч би явах байсан уу? даа...

Гучин нэгэн нас гэдэг

Гуниж явдаг нас бас бишсэн...

Яав ч би хар буруу санасангүй ээ!

Язгуур угсаа тайж гэдэг үнэн!

Холын Германд сурсан, танилтай нь үнэн!

Хожим л намайг ойлгоосой билээ дээ ” [Ж.Болд-Эрдэнэ.4. №29]

гэж амьдралынхаа мөч бүрийг эргэн дурсаж байгаагаар суут зохиолчийнхоо уран сайхны дүрийг туурвин бүтээсэн нь харагдаж байна. Яруу найрагч З.Доржийн “Миний үйлдсэн нүгэл” Нацагдоржийн номон дээгүүр алхаж гарсандаа гэмшиж бичсэн шүлэг. (1984) энэ шүлэгтээ:

*“Арван наймтайдаа Нацагдоржтой хэрэв би уулзсан бол
Алдарт тэр хүнийг омдоох байсан нь лав биз
Баргар царайтай ундуу, гундуу явахад нь
Басамжилсан нүдээр харах байсан байх
“... Эсэргүүтнийг өмөөрсөн хэрэгт орчихно гээд
Эндүүрч айгаад дүмбийж суух байсан байх”*

гэж өгүүлээд энэхүү санаагаа улам өргөжүүлж улмаар утга уянгын “би” баатрын бодолд шингээж:

*“Арван наймтайдаа Нацагдоржийн зохиол дээгүүр
Алхаад гарч байсныгаа санахлаар
Агуу их хүнтэй хаа нэгтэй уулзаад
Андуу зөрүү харьцсан харьцсан чинээ зовх юм” [З.Дорж.9 х 60]*

гэсэн нь цаанаа шүүмжлэлтэй өргөн санааг гүнзгий агуулсны дээр, бага залуугийн гэнэн санамсаргүйгээс үйлдсэн нүгэлээ наминчлан алдаагаа ойлгосноо илэрхийлсэн өнгө аястай болсон байна. Яруу найрагч О.Дашбалбар “Биднээс өмнө амьдраад явагсад” (1988) шүлэгтээ:

*“Ирсэн бүхнийхээ тоогоор, хүмүүсийн буцсан хорвоод
Инээд, нулимсны нь зайд би амьдарч явнам.
Мөнгөн сарны туяаг Нацагдорж надад үлдээсэн
Мөрөн голын шуугианыг Равжаа надад хайрласан”*

[О.Дашбалбар.7. №16] гэсэн шүлгээ өөрөөсөө өмнө амьдарч яваад ихийн их үйлсийг бүтээж ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн Нацагдорж, Равжаа, Занабазар, Таагүүр, Пушкин, Сүхбаатар нарын үлдээсэн их өв соёлыг гайхан бишрэн хүндэтгэж явахаа илэрхийлээд нарт орчлонгоос хүмүүс явцааж байгаа хийгээд ирсэн бүхнийхээ тоогоор, хүмүүсийн буцдаг хорвоогийн жам ёсны хуулийг гуниг харуулсны далд асаар бидэнд сануулж, суут Нацагдоржоосоо сарны тухай яруу найргийн олон сэтгэмжийг өвлөн авснаа давхар өгүүлсэн байна. Түүний бичсэн “Д.Нацагдорж” хэмээх шүлэгт ч гуниг харуулсны уянгын зориулал шүлгийн баримт бий.

Яруу найрагч Н.Нямдоржийн “Их Нацагдоржийгоо үгүйлэн өмөөрсөн шүлэг” (1992) хэмээх шүлэгтээ:

*“Хүрдэн дээр бөмбөрөх
Эрхэм их шарилыг тань
Хүн хүнийхээс дотночилж
Нөхөд нь юунд түшсэнгүй вэ?
Хүүр шарил бунхлах
Анир амгалангийн оронд
Хүргэлцэж тэнд очих
Самбаа юунд гараагүй вэ?
Эрхэм таны халуун амийг
Түшсэн гэх
Илүү дотночилж эцсийн замд нь
Үдсэн гэх эгэл хэрнээ*

*Хүний сэтгэл гаргасан хүн
Энэ улсын минь дотор
Ганц байх нь яагаа вэ? [Н.Нямдорж.12 х 30]*

гэж бичсэн.

Манай нэрт яруу найрагч Д.Цоодол “Гүнгийн нууранд агсам тавьж байж ам руугаа алгадуулав” (2006) шүлэгтээ:

*Мөн ч олон удаа эрлээ, Нацагдорж хаачив?
Мөнгөнчиг эмээлтэй, шувуун саарал яасан?
Нүд тусмагц гутчихмаар хунгийн сүрэг тоогоороо
Нүүдэлтэйн цагаан гэрүүд тахилын цөгц шиг тоогоороо
Нар буяны данстай юм болгон байхад
Нацагдорж л алга, тэр хаачсан бэ?
Гүрний чимэг болсон ганц овоо хүүгээ
Гүүргийн дуутай хөндийдөө байлгагаж чадсангүй юу чи гэж
Гүний нууранд би агсам тавилаа
-Энхрийхэн Пагмадуламтай нь эндээ л айл болгохгүй
Эзэн богдын хүрээ, этгээд холын орон руу
Элэнцгээ хийж Нацагдоржийг явуулсан юм бэ? [Д.Цоодол.14.94]*

гэсэн шүлэгт зохиолч Д.Цоодол, суут зохиолчийнхоо төрсөн нутгийн нуурнаас хунгийн сүрэг, тахилын цөгц шиг гэрүүд тоогоороо байхад, гүрний чимэг болсон ганц овоо хүү Нацагдоржийг, Пагмадуламтай нь байлгахгүй этгээд холын орон руу явуулсныг асуулт, хариултын хэлбэрээр бичсэн гуниг, харууслын уянгын зориулал шүлгийн сүүлийн үеийн бичлэгийн нэгэн онцлог илэрч байна. Энэ мэтчилэн нэлээд олон яруу найрагчийн бүтээлд Нацагдоржийгоо дурсан харууссан гуниг, харууслын уянгын зориулал шүлэг цөөнгүй байгаа ажээ.

Д.Нацагдоржид зориулан бичсэн гуниг, харууслын уянгын шүлэгт гуниглалын сэтгэлийн хөдөлгөөний илэрхийлэл бий боловч, тэр гунигийн цаана ирээдүйдээ итгэх ямар нэг гэгээлэг өнгө аяс нууцлагдаж байгаа учраас уран сайхны өгүүлэмжит дүрслэлд өөрөө өөрийгөө өгүүлэн, дүрслэн буй аргын хувьд зохиол дотроо мөнхрөн явж байгаа юм шиг бодогдог нэг хэсэг шүлэг бий. Эдгээр шүлгээс нь үзэхэд зориулал шүлэг нь өөрөө өөртөө зориулж өөрийгөө байцаан, ажил үйлсээ шинжиж тодорхойлсон хэлбэрээр зохиож болдогийн тодорхой баримт баттай эх сурвалж болж баайгаагийн жишээ юм. Учир иймээс энэхүү зохиолчийн дүр зургийг илэрхийлэн гаргасан гуниг, харууслын зориулал уянгын шүлгийг Д.Нацагдоржид өөрт нь тохилдсон ямар нэгэн зүйлийн улмаас өөрөө өөртөө зориулж бичсэн гуниг, харууслын уянгын зориулал шүлэг,

Хэн нэг хүнд тохиолдсон уй гуниг, харууслыг хуваалцахын учир (хайр сэтгэлт хүн, хань ижил, үр хүүхэд, эцэг эх, хамаатан садан, анд найз нөхөд олонд нэр алдар нь түгсэн гавъяат болон суут хүмүүст) *Нацагдоржоос бусдад зориулан бичсэн гуниг, харууслын уянгын зориулал шүлэг,*

Суут зохиолч Д.Нацагдоржид зохиолч нөхдөөс нь зориулан бичсэн гунигийн буюу харууслын уянгын зориулал шүлэг гэх зэргээр ангилан үзэж болох боловч Д.Нацагдоржид зориулан бичсэн гунигийн буюу харсуулын уянгын зориулал шүлэг нэгэнт тогтсон хэв загвартай болсноор түүний өвөрмөц онцлог илэрч байна.

Ном зүй

Эх сурвалж, хэрэглэгдэхүүн

1. Ананда Шри. Н.Ч. (1997) Аавдаа. (шүлэг). Л.Дашнямын орчуулга. “Хонгор хүмүүс”. УБ.,
2. Бадарч П. (1991) Нацагдорж гуайг өрөвднөм. (шүлэг). Намрын хонгор салхи. УБ.,
3. Бадарч П. (2000) Пагмадулам. (шүлэг). Монголын уран зохиолын дээжис 65 дугаар боть. УБ.,
4. Болд-Эрдэнэ Ж. (1989) Д.Нацагдоржийн сүүлчийн өдөр. (шүлэг). “Утга зохиол, урлаг” сонин. №29.
5. Болд-Эрдэнэ Ж. (1989) Бодол. (шүлэг). “Утга зохиол, урлаг” сонин. №29.
6. Дорж З. (2006) Миний үйлдсэн нүгэл. (шүлэг). “Д.Нацагдоржид зориулсан зохиолын дээжис” УБ.,
7. Галсан Т. (1976) “Мөнхжил олсон найрагч” “Утга зохиол, урлаг” сонин. №47.
8. Дашбалбар О. (1988) “Биднээс өмнө амьдраад явагсад” “Утга зохиол, урлаг” сонин. №16.
9. Дашбалбар О. (1983) Д.Нацагдорж. (шүлэг). “Цог” сэтгүүл. №6.
10. Донид Г. (1989) Найрагч шиг найрагчийн дурсгалд. (шүлэг). “Утга зохиол, урлаг” сонин. №11.
11. Нацагдорж Д. (2006) Соё хайрлана, чамайг. (шүлэг). “Бүрэн зохиол-1” УБ.,
12. Нямдорж Н. (1992) Их Нацагдоржийгоо үгүйлэн өмөөрсөн шүлэг. (шүлэг). Үүр. УБ.,
13. Оюун С. (1988) Д.Нацагдорж. (шүлэг). “Утга зохиол, урлаг” сонин. № 35
14. Цоодол Д. (2006) Гүний нууранд агсам тавьж байж ам руугаа алгадуулав. (шүлэг). “Цог” сэтгүүл. УБ., №46
15. Ядмаа З. (1989) Харуусал. (шүлэг). “Утга зохиол, урлаг” сонин. №14.

Судалгааны ном, зохиол

16. Байгалсайхан Д. (1995) Гуниглал шүлэг. “Уран зохиолын шинжлэлийн удиртгал”. УБ.,
17. Балдан Л. (2002) Д.Нацагдоржийн охин Ананда Шрийн тухай тайлагдаагүй долоон асуултын хариу. “Оюун ухаанаараа сэтгэсэн ертөнцийг бүтээсэн хүн”. УБ.,
18. Гаадамба Ш. (1998) Гунигийн уянга. Уй гашуу, эмэгнэл харамслын уянга (Эмэгнэлийн шүлэг) Утга зохиолын онолын үндэс. УБ.,
19. Галбаатар Д. (2002) Утга зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь. Токио.,
20. Дулам С, Ц.Хасбаатар Ц. (1980) Гунигт шүлэг. “Утга зохиолын онолын үүд”. УБ.,
21. Ендон Д. (1995) Орос монгол уран зохиолын нэр томъёоны товч тайлбар толь. УБ.,

РЕЗЮМЕ

В статье рассматривается создание образа великого монгольского писателя Д.Нацагдоржа в посвяительных стихотворениях в современной Монгольской литературе.

В произведениях Д.Нацагдоржа имеет место ряд элегий и скорбных, лирических, посвяительных стихов. Художественным героем серий стихотворений, написанных Д.Нацагдоржом был лирический “Я”- сам Д.Нацагдорж.

Для великого монгольского писателя Д.Нацагдоржа были созданы монгольскими писателями в частности, П.Бадарчом, Ж.Болд-Эрдэнем, Г.Донидом, З.Доржом, Т.Галсаном, О.Дашбалбаром, Н.Нямдоржом, С.Оюун, Д.Цоодолом, З.Ядмой, многие элегий и скорбные, лирические, посвяительные стихотворения.